ТӨРИЙН БАНК
ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА




# И-БИЛЛИНГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАРЫН АВЛАГА

*Хэрэглээний төлбөрөө хялбар төлье!*

# И-БИЛЛИНГ ҮЙЛЧИЛГЭЭНД НЭВТРЭХ






И-Биллинг үйлчилгээг www.statebank.mn хаяг руу хандан авах боломжтой.

Бүртгэлтэй харилцагч “Нэвтрэх нэр” хэсэгт өөрийн бүртгүүлсэн и-мэйл хаягаа бичиж нэвтэрнэ.

Хэрэв та Ибиллинг үйлчилгээнд бүртгэлгүй бол “Шинэ хэрэглэгч болох” цэсийг сонгож бүртгүүлэн хэрэглээний төлбөрөө төлнө.

# ХАЙЛТ




Та орон сууцны хаягаар хайлт хийж хэрэглээний төлбөрөө төлж болно.

Эсвэл орон сууцны төлбөр төлөгчийн код буюу хэрэглэгчийн 16 оронтой кодоор хайлт хийх боломжтой. Хэрэв та хэрэглэгчийн кодоо мэдэхгүй бол өмнө банканд орон сууцны төлбөр төлсөн баримт дээрээс харж болно.

# ТӨЛБӨРИЙН ТӨРӨЛ




**Нэмэх** товчийг дарж хайлт хийсэн орон сууцаа хадгална.

Хэрэглэгчийн код болон гэрийн хаягаар хайлт хийхэд таны төлбөрүүд төрөл тус бүрээр харагдана. Эндээс та төлбөрийн төрлөө сонгож төлөх боломжтой.

Та НӨАТ төлөгч байгууллагын нэр дээр хэрэглээний төлбөр төлж байгаа бол доорх талбарт байгууллагын регистрийн дугаараа оруулна уу.

Цааш гэсэн цэсийг сонгосноор төлбөрийн дэлгэрэнгүй мэдээлэл, төлбөр төлөх сувгууд харагдана.

# ТӨЛБӨР ТӨЛӨХ



e.statebank.mn/ebillingnew/Main.aspx

ТӨРИЙН БАНК
ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

Сайн уу? Chinbat

- Хайлт
- Туслах
- Гарын авлага
- Банкны үйлчилгээ
- ATM
- Салбарууд
- Холбосон хэрэглээний төлбөр
- Харилцагчийн мэдээлэл
- Гүйлгээний түүх харах
- Нууц үг солих
- Гарах

**Төлбөр төлөх**

Хэрэглэгчийн мэдээлэл

| Хэрэглэгчийн код | Хэрэглэгчийн овог нэр | Хаяг |
|---|---|---|
| 2003150004001990 | ТӨГӨЛДӨР | БЗД-15Х 13ХЛ 4 Т-199 |

Нэмэх

Төлбөрийн мэдээлэл

| Төлбөрийн төрөл | Он | Сар | Дүн | Алданги | Нийт |
|---|---|---|---|---|---|
| ТӨГӨЛДӨР: ОСНАА ХҮТ-4 | 2020 | 7 | 11790 | 0 | 11790 |

Нэхэмжлэгч :ОСНАА ХҮТ-4
ТӨГӨЛДӨР : Он сар :2020/7

| | |
|---|---|
| Дулааны суурь хураамж | 5500 |
| Цэвэр ус | 0 |
| Усны суурь хураамж | 3000 |
| Хогны хураамж | 2000 |
| Радио | 330 |
| Баримтын үнэ | 100 |
| НӨАТ-н дүн | 860 |

| Эхний заалт | Эцсийн заалт | Зөрүү |
|---|---|---|
| 466 | 466 | 0 |
| 58 | 58 | 0 |
| 179 | 179 | 0 |
| 586 | 586 | 0 |

**Нийт төлбөр :11790** **Алданги :0**

Та дээрх төлбөрүүдийг төлөх гэж байна.Нийт **11790** төгрөг

Буцах | Карт-р төлөх | Qpay-р төлөх

# Картаар төлөх




Та энэ цэсэнд дараах мэдээллийг оруулна.

1. Картын дугаар: Таны төлбөр төлөх картын дугаар
2. CVV /Card Verification Number/: Таны картын ард, гарын үсэг зурах талбарт буй 3 оронтой тоо
3. Карт эзэмшигч: Таны карт дээр латин үсгээр шивсэн нэр
4. Картын хугацаа: Таны картын хугацаа дуусах огноо

   Мэдээллээ оруулан ЦААШ товчийг дарснаар интернэт пин код бичих хуудсанд шилжинэ. iPIN хэсэгт бичиж ENTER товч дарснаар гүйлгээ амжилттай хийгдэнэ. Энд та банкнаас интернэт пин код аваагүй бол цааш үргэлжлүүлэх боломжгүй болно. Тиймээс доорх зааврын дагуу интернэт пин код авна.

### iPIN – Интернэт пин код авах

iPIN буюу Интернэт пин код нь таны картаа ашиглан интернэтээр төлбөр төлөх, худалдан авалт хийхэд хэрэглэгдэх нууцлал бүхий код юм.

Та iPIN код авах бол дараах байдлаар авах боломжтой.

1. Банкны ЛАВЛАХ 1800-1881 утсанд холбогдон оператороос iPIN авах
2. Төрийн банкны АТМ-аас Нууц дугаар солих / интернэт нууц дугаар авах гэсэн сонголт хийж iPIN авах

Та өөрийн iPIN кодын нууцлалыг хариуцах тул интернэт пин кодоо бусдад мэдэгдэх, тэмдэглэн хадгалахгүй байхыг зөвлөе!

Хэрэв Та интернэт пин кодоо мартсан эсвэл 3 удаа буруу оруулан хаалгасан бол доор зүйлсийг анхаарна уу!

Картаа АТМ-д бүү хий! Таны картаар үйлдэл хийж байгаа нь луйврын гүйлгээ хийгдэж байх эрсдэлтэй тул АТМ шууд хурааж авдаг.

Төрийн банкны дурын салбар, тооцооны төв дээр очиж интернэт пин код болон картын пин кодоо хамтад нь сэргээлгээрэй!

Таны төлбөр төлсөн баримт бүртгүүлсэн и-мэйл хаягт илгээгдэнэ. Хэрэв Та ирсэн төлбөрийн баримтаа баталгаажуулж авахыг хүсвэл Төрийн банкны аль ч салбар, нэгж дээр баримтаа хэвлэж ирэн, теллерээр тамга даруулж авах боломжтой.

Танд асууж, тодруулах зүйл гарвал банкны лавлах 1800-1881 утсанд хандана уу.

# QPay-р төлөх






Танд Төрийн банкны карт эсвэл Гялсбанкгүй бол дурын банкны аппликейшнаар тус QR code-г уншуулж хэрэглээний төлбөрөө төлөөрэй.

Таны НӨАТ-н баримт бүртгэлтэй и-мэйл хаягт илгээгдэнэ.